



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3
<hr/>	
<i>I.Горимын санал</i>	3

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 03 дугаар сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 46 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Жаргалмаа;

Тасалсан: Ц.Туваан.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээч нарын хяналт шалгалтын үр дүнгийн талаар болон тусгай шалгалтын сэдвийн дагуу Түр хороо өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой дотоод асуудал ярих учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

**Ж.Чинбүрэн:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 0

Бүгд: 4

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 03 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 14 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР  
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим 14 цаг  
46 минут.

### ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Чинбүрэн:** Эрхэм гишүүддээ энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье ээ. Хуралдааны ирцийг танилцуулъя. Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Бейсен гишүүн ирсэн байна, Оюунчимэг гишүүн ирсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ ээ. Нэгд шинжээчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл,

2.Хянан шалгагч шинжээч нарт тулгарч буй бэрхиээл тулгамдаж буй асуудлууд болон сонсголын ерөнхий төлөвлөгөөний талаарх асуудлууд байна аа.

Хэлэлцэх асуудлаар өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё

Хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

1.Шинжээчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл,

2.Хянан шалгаж шинжээч нарт тулгарч буй бэрхиээл тулгамдаж буй асуудлууд болон сонсголын ерөнхий төлөвлөгөөний талаарх асуудлууд байна.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу? Алга байна аа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээч нарын хяналт шалгалтын үр дүнгийн талаар мэдээлэл сонсох. Мөн тусгай шалгалтын сэдвийн дагуу түр хороо зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой асуудлыг хэлэлцэх учраас хуралдааныг хаалттай горимоор явуулах саналыг гаргаж байна аа.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийн тус тус үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт хаалттай хуралдъя гэдгээр.

Гишүүдийн 100 хувийн саналаар хаалттай хуралдах дэмжигдлээ.

Хаалттай горимд шилжүүлъя.

Хаалттай горимд шилжлээ.

Гишүүдийн 100 хувийн саналаар хуралдааныг хаалтын горимд шилжлээ.

14.49 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА